


SMI Монголд Танилцуулга





БИД ХЭН БЭ


SMI-ийн тухай

Күинсландын Их Сургуулийн харъяа Тогтвортой Эрдэс Баялгийн Хүрээлэн (ТЭБХ) буюу The Sustainable Minerals Institute (SMI) нь эрдэс баялгийн салбарын тогтвортой хөгжлийн чиглэлээр эрдэм шинжилгээ, сургалтын цогц үйл ажиллагаа явуулдаг дэлхийн хамгийн том байгууллагуудын нэг юм. Манай хүрээлэнд тус их сургуулийн Инженер, Шинжлэх Ухаан, Бизнес, Эрүүл Мэндийн салбар сургуулиудад давхардсан харъяалал бүхий судлаачдыг оролцуулан нийт 400 гаруй сургалт, эрдэм шинжилгээний ажилтан ажиллаж, мөн 150 гаруй оюутнууд магистр болон докторын хөтөлбөрт суралцаж байна. Манай үйл ажиллагаа геологи хайгуулаас эхлээд уурхайлсан газрын нөхөн сэргээлт хүртэл эрдэс баялагийн салбарын бүхий л үе шатуудыг хамардаг.

ТЭБХ нь эрдэс баялгийн салбарын туршлага, чадавхийг сайжруулах, байгалийн нөөцийг урт удаан хугацаанд зохистой ашиглах зорилтыг хэрэгжүүлэхийг төлөө дэлхийн олон орнуудын төр, олон нийтийн байгууллага, ард иргэд, компаниудтай хамтран ажиллаж, шинэлэг, бүтээлч судалгаа, сургалт, шийдлүүдийг нэвтрүүлдэг.

ТЭБХ нь байгалийн болон нийгмийн шинжлэх ухааны эрдэмтэн судлаачид, инженерүүдээс бүрдсэн 7 судалгааны төвтэй. Бид эрдэс баялагийн салбарт тулгамдаж буй адармаатай, олон талт асуудлуудыг шийдэрлэхэд бид тухайн нэг салбарын болон хүрээлэнгийн бусад салбаруудын мэдлэг, чадварыг хамтатгасан цогц шийдлүүд, үйлчилгээгээр хангах чадвартай.





БИДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монголын Судалгааны Нэгдэл

Монголын Судалгааны Нэгдэл нь эрдэс баялагийн салбарт түшиглэсэн Монгол орны хөгжлийн боломж, түүний эргэн тойронд бий болж буй бэрхшээлүүдийг ойлгож мэдэх, судлах зорилготой хамтын ажиллагааны санаачлага юм.

Бидний эрхэм зорилго бол Монгол орны эрдэс баялагийн салбарт хууль, тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах, салбарын тэргүүлэх туршлагаудыг нэвтрүүлэхэд төрийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэхэд оршино.

Бид олон улсын болон монголын мэргэжлийн байгууллагуудтай хамтран уул уурхайтай холбоотой асуудлуудыг улсын болон бүс, орон нутгийн хэмжээнд авч үзэн судалгаа хийж байна. Өнөөгийн байдлаар Монгол орны уул уурхай дах нийгмийн асуудлууд, байгаль орчны менежмент, ажлын байрны эрүүл ахуй аюулгүй ажиллагаа зэрэг чиглэлээр сургалт, эрдэм шинжилгээний төслүүд хэрэгжүүлээд байна.

2013 онд тус хүрээлэнгийн Уул Уурхай дах Нийгмийн Хариуцлагын Төв (SMI-CSRM) Австралийн Засгийн Газрын Дэмжлэгт (Australian Aid) хөтөлбөрийн хүрээнд Хөгжлийн Судалгааны Сангийн Төсөлд шалгарч, судалгааны төсөл хэрэгжүүлэх эрх авсан билээ. Энэхүү эрхийн болзлыг хангасан судалгааны төсөл Австрали улсаас хөгжингүй орнуудад үзүүлж буй дэмжлэг, тусламжийн чанар, үр өгөөжийг сайжруулахад тэргүүлэх үүрэг гүйцэтгэдэг. Тус хүрээлэн дээр Монголын Судалгааны Нэгдэл энэхүү төслийн санаачлагаар үүсгэн байгуулагдсан. "Эрдэс баялагийн ашиглалтын үйл явцаас жендэрийн эрх тэгш байдал, орон нутгийн иргэдийн амьжиргаанд нөлөөлөх байдлыг зохицуулах нь" сэдэвт судалгааны ажлыг 2013 оны 6 сараас эхлэн 2 жилийн хугацаатай хэрэгжүүлж эхлээд байна.

АЖЛЫН ТУРШЛАГА, ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Нийгмийн хөгжил

Уул уурхай дах Нийгмийн Хариуцлагын Төв (УУНХТ) нь Монгол оронд нийгмийн тогтвортой хөгжил, хариуцлагатай уул уурхайг дэмжихэд чиглэсэн сэдэвчилсэн судалгаа, сургалт үйл ажиллагаа явуулж ирсэн.

Тус төвийн Монголд хэрэгжүүлж буй төслүүд нь уул уурхай ба нийгмийн хөгжлийн асуудлуудыг өргөн хүрээнд авч үзэн, эрдэс баялагийн салбарын оролцогч талууд болох хувийн хэвшил, иргэд, төрийн байгууллагууд зэргийн хамтын ажиллагааг дэмжин ажилладаг. УУНХТ-ийн судалгаа, сургалтын үйл ажиллагаа дараах чиглэлээр явагдаж байна. Үүнд:

- Нөөцийн удирдлага
- Жендер ба Хөгжил
- Нийгэм-Экологийн Нөлөөллийн Үнэлгээ
- Гэрээ байгуулалт
- Нийгэм-Эдийн Засгийн Хөгжил ба Жижиг Дунд Бизнесийн Дэмжлэг
- Орон Нутгийн Хөгжил
- Орон Нутгийн Харилцаа
- Нүүлгэн шилжүүлэлт



ТЭБХ нь УУНХТөвийн оролцоотой хэд хэдэн томоохон хамтарсан төслүүдийг дараах чиглэлд хэрэгжүүлж байна. Үүнд:

- Уул урхайгаас нийгэм болон жендерд үзүүлэх нөлөө, уурхайн дэд бүтэцтэй холбоотой Жендерд Тулгуурласан Хүчирхийлэл (ЖТХ), жендерийн тэгш байдлыг дэмжих, жижиг дунд бизнесийн хөгжил, уламжлалт амьжиргаа, уур амьсгалын өөрчлөлт, нүүлгэн шилжүүлэлт зэрэг чиглэлээр гүнзгийрүүлсэн судалгаа
- Орон нутаг дах компани-орон нутгийн харилцааг бэхжүүлэх сургалт
- Орон нутаг, иргэний нийгмийн байгууллагуудыг олон талт оролцоог бэхжүүлэх, орон нутаг ба уул уурхай, ЖТХ ба уул уурхай, орон нутгийн засаг захиргаа ард иргэдийн холбоо харилцааг бэхжүүлэх талаар хэлэлцүүлэг, семинарууд
- Мал аж ахуй болон уул уурхайн салбар уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох, учирсан гарз, хохирол, түүний эрсдлийг хэрхэн бууруулах чадавхийг сайжруулах сургалт хэлэлцүүлгүүд
- Орон нутгийн оролцооны буюу хөгжлийн гэрээ болон компани-орон нутгийн харилцааны чиглэлээрх судалгаа.

Орчны менежмент

ТЭБХ Монгол орны уул уурхайн бүс нутгууд дах байгаль орчны тулгамдсан асуудлуудын хүрээнд сэдэвчилсэн судалгаа, сургалт хийх, мэдээлэл солилцох үйл ажиллагаа явуулдаг. Үүний үндсэн чиглэл нь:

- Уурхайлсан Газрын Нөхөн Сэргээлт
- Уурхайн Хаягдлын Аюулгүй Хадгалалт, Хураагуур
- Уурхайн Хаалт
- Усны хэрэглээ, Хүртээмжийн Асуудлууд
- Байгаль Орчинд Нөлөөлөх Байдлын Үнэлгээ

ТЭБХ Монгол оронд байгаль орчны судалгаа шинжилгээ, боловсрол мэдлэгийг эрдэс баялагийн салбар, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагууд, уурхайн бүс нутгийн ард иргэдэд өндөр түвшинд түгээхийг зорин ажилладаг.

ТЭБХ гүний усны хэрэглээ, байгаль орчны мэдлэг дээшлүүлэлт, байгаль орчны шилдэг туршлагаудыг сурталчлах чиглэлээр тодорхой тооны төслүүдийг хэрэгжүүлж байна. Уурхайлсан Газрын Нөхөн Сэргээлтийн Төв, Эрдэс Баялагийн Салбар дах Усны Төв хамтран байгаль орчны менежмент, уурхайн хаалт, түүний дотор орон нутгийн гарын авлагыг хэрхэн бэлтгэх талаар хэд хэдэн экскурс, сургалтын ажлыг Монголын төрийн болон иргэний нийгмийн байгууллагын төлөөллүүдэд зориулан зохион байгуулж байсан.


Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

ТЭБХ-ийн Эрдэс Баялагийн Салбарын Аюулгүй Байдал Эрүүл Ахуйн Төв нь Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газартай хамтран Монголын уул уурхайн салбар дах Хөдөлмөрийн Аюулгүй Байдал, Эрүүл Ахуй (ХАБЭА)-н нөхцөлийг сайжруулах чиглэлд тогтоосон уламжлалт харилцаатай. Тус төв томоохон болон бага оврын уурхайн ХАБЭА-н асуудлууд дээр дараах чиглэлд дагнан ажилладаг. Үүнд:

- Уул Уурхайн Салбар дах ХАБЭА
- Эрсдлийн Менежмент
- Ажлын Байрны Ариун Цэвэр
- Аюулын Менежмент

ТЭБХ нь ХАБЭА-н шилдэг туршлагаудыг Монгол орны эрдэс баялагийн салбарын хууль, тогтоомжуудтай уялдуулан нэвтрүүлэхийг зорин ажилладаг.

Тус төвөөс олон улсын мэргэжилтнүүдийн баг Монголын уул уурхайн байцаагчдын ажлын байрны ариун цэвэр, дотоод хяналтыг уурхайд сайжруулах тухай сургалт зохион байгуулсан.



ХАМТЫН АЖИЛЛАГАА

Сургалт, судалгааны ажлын дагуу ТЭБХ Монголын төрийн болон боловсрол, иргэний нийгмийн байгууллагуудтай нягт харилцан хамтран ажилладаг. Хамтрагч байгууллагууд:

Төр

- Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар
- Ашигт Малтмалын Хэрэг Эрхлэх Газар
- Жендерийн Тэгш Байдлын Үндэсний Хороо
- Уул Уурхайн Яам
- Байгаль Орчин Ногоон Хөгжлийн Яам
- Өмнөговь, Баянхонгор аймгийн ЗДТГ

Боловсрол

- Монгол Улсын Их Сургууль National University of Mongolia (МУИС)
 - Нийгмийн Шинжлэх Ухааны Факултет дэх Нийгэм, Соёлын Антропологийн Тэнхим
 - МУИС-UNESCO-ИТС Зайнаас Тандан Судлагаа/Газарүйн Мэдээллийн Систем, Орон Зайн Шинжлэх Ухааны Лаборатори
- ШУА-ын Газарзүйн Хүрээлэн
- Австралийн Үндэсний Их Сургууль
 - Кроуфордын Сургууль – Ази Номхон Далайн Нөөцийн Менежмент Хөтөлбөр

Иргэний нийгэм

- Дэлхийн Банк
- Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк
- Азийн Хөгжлийн Банк
- Зохистой Хөгжил Жендер Төв
- Иргэний Шийдэл ТББ
- Зэрлэг Амьтдыг Хамгаалах Нийгэмлэг
- Азийн Сан
- Германы Гео Шинжлэх ухаан Байгалийн нөөцийн Хүрээлэн
- Уул уурхайн Салбарын Институцийг Бэхжүүлэх Техникийн Туслалцаа Төсөл

Хувийн хэвшил

- Рио Тинто ХК
- Шарын Гол ХК
- Эрдэнэс Таван Толгой ХХК
- Энержи Ресурс ХХК
- БЧБ Биллитон ХК



Утас +61 7 3346 4003
Факс +61 7 3346 4045
Вэб www.smi.uq.edu.au
Хаяг Тогтвортой Эрдэс Баялагийн Хүрээлэн
Күинсландын Их Сургууль
Ст Лусия КЛД 4072
Австрали Улс

ABN 63 942 912 684
CRICOS Provider No: 00025B

COPYRIGHT

Энэхүү баримт бичигт агуулагдах мэдээлэл нь ТЭБХ-ийн бүрэн өмч бөгөөд ТЭБХ-ийн хэвлэмэл зөвшөөрөлгүй бүтнээр болон хэсэгчлэн хуулбарлах, хэвлэн нийтлэхийг хатуу хориглоно.